



Эдийн засгийн ТӨЛӨВ

Монголбанк

Мөнгөний бодлогын газрын захирал

Б.Баярдаваа

2022.10.25

1

Гадаад эдийн засгийн орчин

гадаад эрэлт, гадаад инфляц, түүхий эдийн үнэ

2

Дотоод эдийн засгийн орчин

инфляц, эдийн засгийн өсөлт, мөнгө зээл, төлбөрийн тэнцэл



Гадаад эдийн засгийн орчин


Дэлхийн эдийн засгийн төлөв муудав.



№	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	Дэлхийн эдийн засгийн өсөлт (%)	
			2022 он	2023 он
1	ОУВС	2022.10.11	3.2	2.7
2	Дэлхийн банк	2022.06.07	2.9	3.0
3	НҮБ	2022.09.01	2.8	3.1
4	The EIU	2022.07.20	2.8	2.5
5	Barclays	2022.09.12	1.5	2.2
6	UBS	2022.08.11	2.9	3.0
7	Oxford Economics	2022.08.12	3.0	2.4
8	Bank of America Merrill Lynch	2022.08.12	3.0	2.7
Дундаж			2.8	2.7

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд, Блүмберг

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



• **Гадаад эрэлт буурав.** Ихэнх улс орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл буурсан. Үүнд:

- Геополитикийн хүндрэл
 - Худалдааны хязгаарлалтууд, тээвэр логистикийн гацаа, хүнсний болон эрчим хүчний үнийн өсөлт
 - Шинэ хурцадмал байдлууд үүсч болзошгүй
- БНХАУ-ын Тэг-Ковид бодлого
- Улс орнуудын мөнгөний бодлого эрчимтэй чангарсан



Үр дагавар:

- Эрдэс бүтээгдэхүүний үнэ (гадаад худалдааны нөхцөл муудах)
- Эрчим хүчний үнийн өсөлт хадгалагдах
- Нефть экспортлогчдоос бусад улсуудын өсөлт саарах
- Аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний үнэ буурах
- Инфляц 2023 онд Төв банкуудын зорилтоос өндөр байх
- Дэлхийн санхүүгийн нөхцөл хатуурах: Зээл, дахин санхүүжилтийн хүү өсөх


Глобал инфляц энэ онд өндөр түвшинд хадгалагдаж, алгуур буурахаар байна



№	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	Дэлхийн инфляц	
			2022 он	2023 он
1	OYBC	2022.10.11	8.8	6.5
2	The EIU	2022.07.20	9.2	5.7
3	Barclays	2022.08.12	6.7	3.7
4	UBS	2022.08.11	8.2	4.3
5	Oxford Economics	2022.08.12	7.7	4.1
6	Bank of America Merrill Lynch	2022.08.12	8.4	5.8
7	Deutsche Bank	2022.08.12	8.3	5.7
8	ING Group	2022.08.12	6.2	4.4
Дундаж			8.2	5.1

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд, Блумберг

Дэлхийн контейнерийн үнийн индекс (Freightos),
/2019=100/



Гадаад инфляц эрчимтэй нэмэгдэхэд:

- Эрчим хүч, хүнсний үнэ хүлээлтээс илүү хурдацтай өссөн.
- Нийлүүлэлтийн шалтгаантай инфляц өндөр түвшинд хадгалагдаж байна.
- Цар тахлын нөлөө багассантай холбоотойгоор улс орнуудын эрэлт сэргэсэн.

Улс орнуудын жишээ:

- АНУ-ын инфляц 9-р сарын байдлаар 8.2 хувьд хүрч, өндөр түвшинд хадгалагдснаар ХНБ цаашид бодлогын хүүгээ дахин эрчтэй нэмэгдүүлэх хүлээлтийг зах зээлд үүсгэлээ.
- Евро бүсэд инфляц 10 хувьд хүрсэн нь Европын холбоо байгуулагдсанаас хойшхи хамгийн дээд түвшин юм.

Олон улсын тээвэр, логистикийн зардал:

- Улс орнуудын хувьд тээвэр логистикийн зардал буурах хандлагатай байна.
- Гэхдээ олон улсын контейнер тээврийн зардал хэвийн үетэй харьцуулахад 3 дахин өндөр байна.

Түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдах хандлагатай байна



Түүхий эдүүд	2022Q3	2022*	2023*	2024*
Зэс	7985	8781	8100	8447
Нүүрс (Австрали)	286	342	287	250
Алт	1661	1793	1713	1712
Газрын тос	90	102	91	84
Төмрийн хүдэр	95	114	98	88

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд, Блүмберг

- БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын тогтворгүй байдал, Тэг-Ковид бодлого үргэлжлэхэс үүдэн Монгол Улсын экспортын гол түүхий эдийн үнийн төлөв муудаж байна.
- Глобал эдийн засгийн идэвхжил суларсан нь эрчим хүчнээс бусад түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж байна.
- Харин геополитикийн хүндрэлээс шалтгаалсан хязгаарлалтууд эрчим хүчний түүхий эдийн үнийг нэмэгдүүлж байна.
 - Байгалийн хий болон эрчим хүчний нүүрсний үнэ огцом өсөөд байна.



Дотоод эдийн засгийн орчин




Инфляция

Инфляцын талаас илүү хувь импортын барааны үнийн өсөлтийн шууд нөлөөнөөс хамаарч байна





Бүлэг	Жилийн өсөлт		Жилийн инфляцид эзлэх нэгж хувь		
	8 сар	9 сар	8 сар	9 сар	
Импортын бараа /хүнсний бус/	12.5%	12.6%	4.3%	4.4%	▲
Импортын хүнс	28.7%	27.4%	1.8%	1.7%	▼
Шатахуун	28.9%	26.8%	1.7%	1.6%	▼
Дотоодын мах	1.7%	1.4%	0.2%	0.1%	▼
Махнаас бусад дотоодын хүнс	27.3%	23.9%	2.9%	2.6%	▼
<i>Хүнсний ногоо</i>	62.4%	44.0%	0.6%	0.4%	▼
Үйлчилгээ	9.9%	9.9%	1.7%	1.7%	≈
Дотоодын бараа	16.4%	16.5%	1.3%	1.4%	▼
Төрийн зохицуулалттай	5.8%	5.0%	0.5%	0.4%	▼
Нийт			14.4%	13.8%	



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

- Энэ оны 9-р сарын байдлаар ХҮИ-ээр хэмжигдэх инфляц улсын хэмжээнд **13.8** хувь, Улаанбаатар хотод **14.0** хувь байлаа.
- Улсын хэмжээнд сарын инфляц **-0.2%** гарснаар сүүлийн 2 сар сөрөг гарлаа. Үүнд улирлын нөлөө өндөр байв.
- Инфляцын **55** хувийг импортын барааны үнийн өсөлтийн шууд нөлөө бүрдүүлж байна.
- Энэ нь нэг талаас гадаад орчинд бий болсон өөрчлөлт, тээвэр логистикийн асуудлууд манай улсын инфляцын суурь шалтгаан болж байгааг харуулж байна.
- Уул уурхайн бус салбарууд, хувийн хэрэглээ цартахлын өмнөх түвшинг давсан нь эрэлтийн шинжтэй инфляцын дарамт нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

Инфляц алгуур буурахаар байна.



- Нийлүүлэлтийн шинэ шок үүсэхгүй тохиолдолд инфляц алгуур буурах хүлээлттэй.
- Үнэ-Цалин ээлжлэн өсөх үзэгдэл болон үнийн өсөлтийн 2 дахь үеийн нөлөө үүсэж болзошгүй байна. Хэрэв цалин хурдтай /инфляцаас давж/ нэмэгдвэл инфляцын төсөөлөл нэмэгдэнэ.
- Инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулах шаардлагатай.
- Энэ нь мөнгөний бодлого хатуурах зайлшгүй нөхцөл болно.
- Төсөөллийн тодорхой бус байдал өндөр байна.

Инфляцын гол эрсдэлүүдэд суурилсан хувилбар төсөөлөл




Инфляц суурь төсөөллөөс өөрчлөгдөж болзошгүй олон тооны эрсдэл байгаа тул инфляцыг өсгөх болон бууруулах гадаад, дотоод хүчин зүйлсийн тохиолдох магадлалыг харгалзан макро үзүүлэлтүүдийн хувилбар төсөөллийг тусад нь боловсрууллаа.

Инфляцыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийн хувьд:

- 1) Гадаад үнүүд өсөх
- 2) Тээврийн үнэ өсөх
- 3) Газрын тосны үнэ өсөх
- 4) Зээлийн хэмжээ ирэх онд өсөхгүй байх
- 5) Нэрлэсэн цалин өсөх
- 6) Төсвийн зардал тэлэх.

Харин инфляцыг бууруулах хүчин зүйлсийг дээрх эрсдэлүүд суурь төсөөлөлд авч үзсэнээс буурах тохиолдлын илрэх магадлалыг харгалзав.





Эдийн засгийн өсөлт

Дотоод эдийн засаг цар тахлын өмнөх үеийг давлаа



жилийн өсөлт	2020	2021	2022 Н1	2022 Н1/ 2019 Н1
Нийт эрэлт	-4.4	1.6	1.9	0.1
Эцсийн хэрэглээ	4.5	-2.7	6.4	3.7
Хөрөнгийн нийт хуримтлал	-40.7	80.7	43.3	55.1
Экспорт	-5.3	-14.6	-16.0	-29.9
Импорт	-15.5	13.6	18.3	7.8
Нийт нийлүүлэлт	-4.6	1.6	1.9	-1.4
Уул уурхай	-9.9	0.8	-28.8	-39.7
Уул уурхайн бус	-3.7	1.8	6.4	5.2
ХАА	5.8	-5.5	11.3	19.4
Боловсруулах	3.4	-0.9	-2.2	2.9
Барилга	-3.2	-22.8	-8.7	-40.9
Худалдаа	-12.5	5.8	12.2	0.3
Тээвэр	-18.2	-7.3	-22.5	-42.1
Бусад үйлчилгээ	-2.6	3.8	4.6	0.4
Бүт. цэвэр татвар	-9.4	12.2	11.8	20.9



Нийт эрэлт:

- **Эцсийн хэрэглээ** цар тахлын өмнөх үеэс **3.7 хувиар** даваад байна. Энэ нь эрэлт сэргэж буйг илтгэж байна.
- Хөрөнгийн нийт хуримтлал дотоод эрэлт сэргэхэд голлон нөлөөлсөн хэвээр байна
 - Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт
 - Эргэлтийн хөрөнгө

Нийт нийлүүлэлт:

- **Уул уурхайн бус** салбаруудыг нийт дүнгээр нь тооцвол 2019 оны мөн үеэс **5.2 хувиар** өндөр байгаа нь дотоод эдийн засаг цар тахлын өмнөх үеийг давсныг илтгэж байна.
- Тодруулбал, уул уурхай, барилга, тээврийн салбараас бусад салбарууд 2019 оны мөн үеийн түвшинд хүрлээ.
- Харин уул уурхайн салбар уналттай хэвээр байгаа бөгөөд энэ нь томоохон сөрөг үр дагавартай байна.

Эдийн засгийн өсөлт энэ онд 3 хувь, ирэх онд 4 орчим хувьд хүрэх ТӨЛӨВТЭЙ.



Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

- Оны сүүлийн хагаст экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд, тэр дундаа нүүрсний экспорт эрчимжих тохиолдолд эдийн засаг энэ онд 3 орчим хувийн өсөлттэй гарах хүлээлттэй.
- Экспорт хэвийн түвшинд хүрч, зээлийн тасалдал, нийлүүлэлтийн шинэ шок үүсэхгүй байх тохиолдолд ирэх онд эдийн засаг 4 орчим хувь өсөх урьдчилсан тооцоололтой байна.

- Олон улсын байгууллагуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2022 онд 1.7-2.5 хувийн хооронд бол 2023 онд 4.9-5.5 хувь байна.




МӨНГӨ, ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эх үүсвэрийн долларжилт нэмэгдэж, зээлийн өсөлт саарч эхэллээ...




Банкны системийн зээл



- Зээлийн жилийн өсөлт 4-р сараас эхлэн саарч эхэлсэн бөгөөд 9-р сард 13.7 хувьд хүрлээ.
- Зээлийн өсөлт саарахад:
 - Активын чанарын үнэлгээ
 - Төлбөрийн тэнцлийн алдагдал нөлөөлж байна.

Банкны системийн долларжилт









- Хадгаламжийн долларжилт нэмэгдэж 9-р сард 32.2 хувьд хүрэв. Үүнд:
 - Төгрөгийн ханш, түүний хүлээлт
 - Төлбөрийн тэнцлийн алдагдал нөлөөлж байна.





Банкуудын хадгаламжийн хүү



Зөрүү 2021.12 2022.10



Банкуудын хадгаламжийн хүү



Эх сурвалж: Арилжааны банкуудын цахим хуудас




Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж байна.



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Төгрөгийн ханш бусад улсын валютын эсрэг 2022 оны 9 сарын байдлаар



- Төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, 2022 оны эхний 8 сарын байдлаар 1.5 тэрбум ам.долларт хүрлээ. Үүнд урсгал тэнцлийн алдагдал голчлон нөлөөлөв.
 - Хилийн хязгаарлалттай холбоотойгоор экспортын **БОДИТ** орлого төдийлөн сэргээгүй.
 - Томоохон дэд бүтцийн төслүүдээс шалтгаалан импортын өсөлт эрчимжсэн.
- Цаашид дараах хүчин зүйлс төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөхөөр байна.
 - Нүүрсний экспортын шинэ гэрээнүүд харьцангуй өндөр үнээр хийгдэх
 - Экспортын биет хэмжээ нэмэгдэх
 - Импортын өсөлт саарах
- Гэхдээ дээрх хүчин хүчин зүйлс гарах урсгалыг нөхөж чадахааргүй байна.
- Валютын ханшийн тохиргоо эдийн засгийн суурь нөхцөлүүдтэй уялдан, сулрах чиглэлд хийгдэж байна.

**Анхаарал хандуулсанд
баярлалаа**